



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2024 оны 04 сарын 25-ны  
өдрийн 6781 дугаарт бүртгэв.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Г “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд 7  
хувийн дугаар олгох журам”-ыг  
шинэчлэн батлах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд  
хувийн дугаар олгох журам”-ыг  
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД ХУВИЙН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувийн дугаар (цаашид “хувийндугаар” гэх) нь 11 оронтой тоогоор илэрхийлсэн код байх ба эхний орон нь бүртгэх байгууллагыг, хоёр дахь орон нь хувь хүн, хуулийн этгээдийн аль нь болохыг, гурав дахь орон нь бүртгүүлсэн байгууллагын бүс нутгийн байршлыг, дөрөв болон тав дахь орон нь бүртгүүлсэн байгууллагын аймаг, дүүргийн байршлыг, зургаа болон долоо дахь орон нь бүртгэл олгосон оны сүүлийн хоёр орныг, наймаас арван нэг дэх орон нь бүртгэсэн эрх бүхий байгууллагын бүртгэлийн дугаарыг илэрхийлнэ.

1.3.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбарын хувийн дугаарыг тухайн хуулийн этгээдийн энэ журмын 1.2-т заасан үндсэн хувийн дугаараас хойш гурван оронгоор илэрхийлнэ.

### **Хоёр.Хувийн дугаар олгох**

2.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан харьяалах бүртгэх байгууллага нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаарыг олгож, бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийнэ.

2.2.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд бүртгэлийн дугаарт өөрчлөлт оруулахгүй.

2.3.Хувийн дугаарын сүүлийн дөрвөн орныг олгохдоо шинэ он эхлэх бүр эхнээс нь дугаарлах бөгөөд хуулийн этгээд буюу “барьцаалан зээлдүүлэх газар”, хувь хүн буюу “зээлийн үйлчилгээ” эрхлэх этгээдийг харгалзахгүй дараалуулан дугаарлана.

2.4.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбарын хувийн дугаарыг олгохдоо огноо үл хамааран тухайн хуулийн этгээдийг салбар байгуулах тухай бүр дараалуулан дугаарлана.

2.5.Хүчингүй болсон хувийн дугаарыг дахин олгохгүй.

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд  
хувийн дугаар олгох журам”-ын хавсралт

№	ДЭЛГЭРЭНГҮЙ	ТОВЧЛОЛ
1	Санхүүгийн зохицуулах хороо	1
	Нийслэлийн Засаг дарга	2
	Аймгийн Засаг дарга	3
2	Хувь хүн	1
	Хуулийн этгээд	2
3	Улаанбаатарын бүс	1
	Зүүн бүс	2
	Төвийн бүс	4
	Хангайн бүс	6
	Баруун бүс	8
4	Дорнод аймаг	21
	Сүхбаатар аймаг	22
	Хэнтий аймаг	23
	Төв аймаг	41
	Говьсүмбэр аймаг	42
	Сэлэнгэ аймаг	43
	Дорноговь аймаг	44
	Дархан-Уул аймаг	45
	Өмнөговь аймаг	46
	Дундговь аймаг	48
	Орхон аймаг	61
	Өвөрхангай аймаг	62
	Булган аймаг	63
	Баянхонгор аймаг	64
	Архангай аймаг	65
	Хөвсгөл аймаг	67
	Завхан аймаг	81
	Говь-Алтай аймаг	82
	Баян-Өлгий аймаг	83
	Ховд аймаг	84
	Увс аймаг	85
	Багануур дүүрэг	01
	Багахангай дүүрэг	04
	Баянгол дүүрэг	07
	Баянзүрх дүүрэг	10
	Налайх дүүрэг	13
	Сонгинохайрхан дүүрэг	16
	Сүхбаатар дүүрэг	19
	Хан-Уул дүүрэг	22
	Чингэлтэй дүүрэг	25

Жишээ нь: “12122220001” гэсэн хувийн дугаар нь Санхүүгийн зохицуулах хорооноос Барьцаалан зээлдүүлэх газрыг Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт 2022 онд 1 дугаарт бүртгэсэн гэх утгыг илэрхийлнэ.

Аймаг, нийслэлийн кодыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн [2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор баталсан Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг](#) баримтлан дугаарлана.

Салбарын хувьд: 12122220001-001 гэж дугаарлана.

---oO---